



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2024/20/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Хосжаргал
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
Ахлах аудитор: В.Эрдэнэцогт
Утас: 262071 Цахим хаяг: erdenetsogtv@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Тэд-Аудит" ХХК-ийн ерөнхий
захирал: Ц.Сугармаа
Утас: 99151254 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	20
5.2 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Албан шаардлага	20
5.2 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

2024.02.23 № 07/313

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус эмнэлэг нь Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 71 дүгээр тогтоолыг үндэслэн эрхтэн шилжүүлэн суулгуулсан иргэдэд дархлаа дарангуйлах зориулалттай эм худалдан авах Нидерланд Улсын Астеллас компанитай хийсэн гэрээний дагуу 3-4 сарын өмнө захиалан тайлант онд нийт 8,296.566.3 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл бэлтгэжээ.

Аудитын гол асуудал

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн УБ-01/036 дугаар бүхий "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ худалдан авах тухай" гэрээний 2.4.2-т "төсвийн тухай хуульд заасан санхүүгийн тайлангийн цаглабартай холбогдуулан тухайн төсвийн жилийн 6, 12 дугаар сард үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг тухайн сарын 10-ны өдрөөр тасалбар болгох...", "11-ний өдрөөс сар дуусах хугацаанд үзүүлсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг дараа сарын нэхэмжлэхтэй хамтатган хүргүүлэх" гэж заажээ. Ингэснээр нийт 5,012,096.8 мянган төгрөгийн санхүүжилтийг тайлант жилийн гүйцэтгэлд тооцоогүй, тухайн байгууллагын орлогыг бууруулж, өр авлагыг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан баталгаажуулах боломжгүй болгосон байна.

Эрүүл мэндийн яамнаас 2022 онд 11 нэр төрлийн 1,073,237.4 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл шилжүүлснээс тайлант онд 155,605.6 мянган төгрөгийн буюу 14.5 хувийг зарцуулж, 917,631.8 мянган төгрөгийн буюу 85.5 хувь нь жилийн эцсийн байдлаар хугацаа дууссан болон удаан ашиглагдахгүй байгаа ба бараа материалын үлдэгдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 11 зорилтын хүрээнд 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл 97.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,456,226,427.60	42,588,155,813.10
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,092,874,182.93	350,883,218.16
31110	Касс	-	-
31130	Нэмэлт санхүүжилт	-	-
31211	Төрийн сангийн харилцах	5,079,942,857.08	350,883,218.16
31213	Арилжааны банк дахь харилцах	4,680,000.00	-
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	8,251,325.85	-
33	АВЛАГА	3,272,550,733.85	16,903,438,025.67
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	330,000.00	8,412,110.91
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,151,991,250.00	16,799,451,850.07
3350	Бусад авлага	-	95,574,064.69
3351	Байгууллагаас авах авлага	39,207,883.85	90,198,064.69
3352	Хувь хүмүүсээс авах авлага	81,021,600.00	5,376,000.00
34	УРЬДЧИЛГАА	209,555,857.00	36,827,503.13
34713	Урьдчилгаа төлбөр	209,555,857.00	36,827,503.13
35	БАРАА МАТЕРИАЛ	10,881,245,653.82	25,297,007,066.14
351	Түүхий эд материал	6,391,883,666.79	20,222,845,330.68
35130	Эм боох материал	6,391,883,666.79	20,222,845,330.68
35470	Бусад хангамж	4,032,596,019.31	4,728,830,948.53
35400	Хангамжийн материал	456,765,967.72	345,330,786.93
35410	Бичиг хэргийн материал	12,352,004.31	10,403,113.36
35420	Аж ахуйн материал	16,122,527.98	38,781,997.70
35430	Сэлбэг хэрэгсэл	416,049,397.78	278,485,539.91
35440	Түлш, шатах тослох материал	5,773,637.65	5,544,371.29
35450	Барилгын засварын материал	6,468,400.00	12,115,764.67
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	57,352,264,720.23	55,156,384,889.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	57,352,264,720.23	55,156,384,889.92
39201	Барилга, байгууламж, орон сууц	26,646,737,429.49	28,864,182,054.49
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,765,555,891.51	-2,225,846,272.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	336,623,416.00	336,623,416.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-203,643,427.50	-229,820,361.81
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	70,102,256,734.14	71,115,667,754.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-40,761,929,232.96	-45,518,764,130.56
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,049,415,554.33	1,105,719,749.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	-624,907,905.69	-720,962,752.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,960,121,366.71	1,971,621,366.71
39215	Хуримтлагдсан элэгдэл	-241,219,981.70	-385,972,510.81
39301	Биет бус хөрөнгө	122,891,903.00	122,891,903.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-98,910,344.08	-109,340,425.93
39303	Бусад биет бус хөрөнгө	830,385,100.00	830,385,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	76,808,491,147.83	97,744,540,703.02
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,631,476,952.74	20,538,412,325.53
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,631,476,952.74	20,538,412,325.53
412	Богино хугацаат зээлийн өглөг	29,200,596.85	26,126,849.40
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	29,200,596.85	26,126,849.40
413	Өглөг	1,282,280,919.89	20,512,285,476.13
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	123,576.00	963,185.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ӨӨРЧЛӨЛТГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

6

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

4136	Бусад өглөг	1,282,157,343.89	20,511,322,291.13
41361	Байгууллагад төлөх өглөг	1,281,453,343.89	20,511,322,291.13
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	704,000.00	0.00
414	Урьдчилж орсон орлого	319,995,436.00	0.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	319,995,436.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	75,177,014,195.09	77,206,128,377.49
51	Засгийн газрын хувь оролцоо	75,177,014,195.09	77,206,128,377.49
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,376,629,291.33	21,376,629,291.33
512	Хуримтлагдсан үр дүн	44,385,790,970.62	46,414,905,153.02
51210	Өмнөх үеийн үр дүн	28,283,906,769.58	44,385,790,970.62
51220	Тайлант үеийн үр дүн	16,101,884,201.04	2,029,114,182.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,414,593,933.14	9,414,593,933.14
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	76,808,491,147.83	97,744,540,703.02

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	96,631,990,439.10	88,165,912,730.04
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,226,997,274.38	11,212,017,098.46
120	Нийтлэг татварын бус орлого	22,226,997,274.38	11,212,017,098.46
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,178,513,295.52	5,458,940,017.48
120041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,274,194,705.43	5,458,940,017.48
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,188,556,629.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	11,029,585,648.30	966,671,243.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	1,874,732,941.79	597,849,208.76
120005	Түрээсийн орлого	263,254,372.80	0
120009	Бусад орлого	3,785,229,606.06	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	74,404,993,164.72	76,953,895,631.58
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	74,404,993,164.72	76,953,895,631.58
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	74,404,993,164.72	76,953,895,631.58
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	80,530,106,238.06	86,136,798,547.64
21	УРСГАЛ ЗАРДАЛ	80,517,553,618.14	86,136,798,547.64
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,599,890,155.79	85,538,137,458.93
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	22,795,745,639.54	28,906,325,590.72
210101	Үндсэн цалин	12,637,768,989.82	15,867,034,972.35
210102	Нэмэгдэл цалин	7,345,481,685.94	10,617,135,748.34
210103	Унаа хоолны хөнгөлөлт	861,475,000.00	1,038,461,275.42
210104	Урамшуулал	1,951,019,963.78	1,383,693,594.61
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,885,196,751.94	3,660,999,017.46
210201	Тэтгэврийн даатгал	1,924,437,318.59	2,520,508,183.22
210202	Тэтгэмжийн даатгал	232,970,057.37	295,714,886.21
210203	ҮОМШ өвчний даатгал	183,630,771.57	231,285,494.12
210204	Ажилгүйдлийн даатгал	45,024,978.07	55,413,658.26
210205	Эрүүл мэндийн даатгал	499,133,626.34	558,076,795.65
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,242,195,844.05	1,083,855,603.00
210301	Гэрэл цахилгаан	646,204,430.82	544,722,603.71

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	197,509,271.23	213,509,595.40
210303	Цэвэр, бохир ус	398,482,142.00	325,623,403.89
2104	Хангамж, бараа материалын зардал	1,795,431,803.97	775,245,272.95
210401	Бичиг хэрэг	161,093,384.39	182,508,173.06
210402	Тээвэр шатахуун	43,439,166.14	45,779,016.50
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	25,331,521.93	32,165,946.58
210404	Ном хэвлэлийн зардал	2,600,000.00	8,404,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	601,033,382.90	423,155,445.17
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	961,934,348.61	83,232,691.64
2105	Нормативт зардал	36,918,377,145.51	41,719,002,530.79
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	35,715,413,970.59	40,169,212,564.79
210502	Хоол, Хүнс	1,177,338,620.00	1,545,904,400.00
210503	Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах	25,624,554.92	3,885,566.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,410,028,805.83	1,351,032,456.44
210601	Багаж, техник хэрэгсэл	4,980,000.00	104,006,125.85
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,650,000.00	-
210604	Урсгал засвар	1,400,398,805.83	1,247,026,330.59
2107	Томилолт, зочны зардал	16,820,100.00	60,119,994.00
210701	Гадаад албан томилолт	-	50,858,084.00
210702	Дотоод албан томилолт	16,820,100.00	9,261,910.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,417,975,240.30	1,127,840,611.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,349,817,997.30	1,038,451,691.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,000,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,392,990.00	2,392,990.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,945.00	506,919.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	0.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	47,822,268.00	66,107,971.00
210807	Газрын төлбөр	5,381,040.00	5,381,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,118,118,824.65	6,853,716,382.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,102,689.93	501,466,670.27
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	4,976,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	5,918,016,134.72	6,347,272,812.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	917,663,462.35	598,661,088.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	917,663,462.35	598,661,088.71
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	323,462.35	591,151,088.71
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	917,340,000.00	7,510,000.00
223001	Бусад хөрөнгө	12,552,619.92	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	16,101,884,201.04	2,029,114,182.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	16,101,884,201.04	2,029,114,182.40

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	БАЛАНСЫН ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	90,409,726,384.61	73,108,343,087.51
1	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,121,276,354.20	9,801,908,056.00
12	Нийтлэг татварын бус орлого	10,121,276,354.20	9,801,908,056.00

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	10,121,276,354.20	9,801,908,056.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,978,230,914.66	5,363,663,721.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	5,143,045,439.54	4,438,224,334.50
120009	Бусад орлого		0
13	Тусламж, санхүүжилтийн орлого	80,288,450,030.41	63,306,435,031.51
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	80,288,450,030.41	63,306,435,031.51
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	80,288,450,030.41	63,306,435,031.51
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,183,679,608.00	75,677,691,707.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,183,679,608.00	75,677,691,707.29
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,980,152,634.00	75,079,030,618.58
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	22,742,813,807.12	28,920,197,857.78
210101	Үндсэн цалин	12,566,260,994.98	15,911,812,093.19
210102	Нэмэгдэл	7,377,549,646.66	10,582,121,779.11
210103	Унаа хоолны хөнгөлөлт	857,413,378.02	1,038,502,313.38
210104	Үр дүнгийн урамшуулал	1,941,589,787.46	1,387,761,672.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,859,631,943.77	3,680,264,509.15
210201	Тэтгэврийн даатгал	1,957,418,689.30	2,540,656,951.44
210202	Тэтгэмжийн даатгал	230,284,591.90	295,371,405.46
210203	ҮОМШӨ-ий даатгал	226,539,599.17	231,113,917.75
210204	Ажилгүйдлийн даатгал	44,448,972.79	55,368,838.32
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	400,940,090.61	557,753,396.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,166,952,313.17	1,531,275,924.46
210301	Гэрэл цахилгааны зардал	637,598,120.82	714,519,921.91
210302	Түлш, халаалтын зардал	170,123,240.35	286,849,938.86
210303	Цэвэр, бохир усны зардал	357,490,952.00	529,906,063.69
210304	Байрны түрээс	1,740,000.00	-
2104	Хангамжийн материалын зардал	543,084,368.09	630,410,937.24
210401	Бичиг хэргийн зардал	94,025,672.60	94,635,167.86
210402	Тээвэр шатахууны зардал	47,381,529.08	40,000,000.00
210403	Шуудан холбооны зардал	20,547,295.47	23,996,946.58
210404	Ном, хэвлэлийн зардал	2,600,000.00	17,429,850.00
210405	Хог хаягдлын зардал	288,863,889.74	399,505,620.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	89,665,981.20	54,843,352.80
2105	Норматив зардал	47,297,401,657.06	37,715,994,512.81
210501	Эм	46,127,204,009.06	35,831,452,010.81
210502	Хоол, хүнс	1,065,617,698.00	1,805,730,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардал	104,579,950.00	78,812,002.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,727,154,990.41	1,344,378,521.92
210601	Багаж хэрэгсэл	327,616,755.04	428,756,460.00
210602	Тавилга	5,770,050.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,650,000.00	-
210604	Урсгал засварын зардал	1,389,118,185.37	915,622,061.92
2107	Томилолт, зочны зардал	15,700,100.00	61,809,520.20
210701	Гадаад томилолтын зардал	-	50,858,084.00
210702	Дотоод томилолтын зардал	15,700,100.00	10,951,436.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал	6,240,724,179.07	571,139,867.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж	6,186,090,469.07	464,277,504.00
210802	Аудитын зэрэглэл тогтоох үйлчилгээ	12,000,000.00	15,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,123,500.00	1,946,600.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	478,845.00	497,419.00

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	110,000.00	9,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,000,000.00	55,526,171.00
210807	Газрын төлбөрийн зардал	5,381,040.00	5,381,040.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх зардал	23,540,325.00	28,501,633.00
2109	Бусад бараа үйлчилгээний зардал	386,689,275.31	623,558,968.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	386,689,275.31	416,162,476.02
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	207,396,492.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,203,526,974.00	598,661,088.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,203,526,974.00	591,151,088.71
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	295,886,974.00	591,151,088.71
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	907,640,000.00	7,510,000.00
213209	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	907,640,000.00	7,510,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	6,226,046,776.61	-2,569,348,619.78
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН(V)	1,186,277,429.15	2,172,642,344.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,186,277,429.15	2,172,642,344.99
2200	Дотоод эх үүсвэрээр	1,186,277,429.15	2,172,642,344.99
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	1,186,277,429.15	2,172,642,344.99
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	5,039,769,347.46	-4,741,990,964.77
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	53,104,835.47	5,092,874,182.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,092,874,182.93	350,883,218.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	28,283,906,769.58	59,075,129,994.05
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	28,283,906,769.58	59,075,129,994.05
4	Тайлант үеийн үр дүн	-	-	16,101,884,201.04	16,101,884,201.04
5	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	44,385,790,970.62	75,177,014,195.09
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	44,385,790,970.62	75,177,014,195.09
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	2,029,114,182.40

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

8	2023 оны 12 - р сарын 31- ний үлдэгдэл	21,376,629,291.33	9,414,593,933.14	46,414,905,153.02	77,206,128,377.49
---	--	-------------------	------------------	-------------------	-------------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

ДАНСНЫ КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,061,180,700.00	77,850,334,052.28	8,210,846,647.72	90.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	86,061,180,700.00	77,850,334,052.28	8,210,846,647.72	90.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	85,035,677,700.00	77,251,672,963.57	7,784,004,736.43	90.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,986,966,600.00	28,920,197,857.78	2,066,768,742.22	93.3
210101	Үндсэн цалин	16,881,664,800.00	15,911,812,093.19	969,852,706.81	94.3
210102	Нэмэгдэл	11,773,752,800.00	10,582,121,779.11	1,191,631,020.89	89.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	983,855,600.00	1,038,502,313.38	-54,646,713.38	105.6
210104	Урамшуулал	1,347,693,400.00	1,387,761,672.10	-40,068,272.10	103.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,873,370,700.00	3,680,264,509.15	193,106,190.85	95.0
210201	Тэтгэврийн даатгал	2,633,892,100.00	2,540,656,951.44	93,235,148.56	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	309,869,700.00	295,371,405.46	14,498,294.54	95.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	247,895,700.00	231,113,917.75	16,781,782.25	93.2
210204	Ажилгүйдлийн даатгал	61,973,900.00	55,368,838.32	6,605,061.68	89.3
210205	Эрүүл мэндийн даатгал	619,739,300.00	557,753,396.18	61,985,903.82	90.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,699,011,500.00	1,531,275,924.46	167,735,575.54	90.1
210301	Гэрэл, цахилгаан	758,341,100.00	714,519,921.91	43,821,178.09	94.2
210302	Түлш, халаалт	353,806,400.00	286,849,938.86	66,956,461.14	81.1
210303	Цэвэр, бохир ус	586,864,000.00	529,906,063.69	56,957,936.31	90.3
2104	Хангамж, бараа материалын зардал	633,792,500.00	630,410,937.24	3,381,562.76	99.5
210401	Бичиг хэрэг	100,401,400.00	94,635,167.86	5,766,232.14	94.3
210402	Тээвэр, шатахуун	40,000,000.00	40,000,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	22,000,000.00	23,996,946.58	-1,996,946.58	109.1
210404	Ном, хэвлэл	17,500,000.00	17,429,850.00	70,150.00	99.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	390,000,000.00	399,505,620.00	-9,505,620.00	102.4

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	63,891,100.00	54,843,352.80	9,047,747.20	85.8
2105	Нормативт зардал	41,639,353,600.00	37,715,994,512.81	3,923,359,087.19	90.6
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	39,604,946,800.00	35,831,452,010.81	3,773,494,789.19	90.5
210502	Хоол, хүнс	1,805,730,500.00	1,805,730,500.00	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	228,676,300.00	78,812,002.00	149,864,298.00	34.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,235,567,700.00	3,517,020,866.91	718,546,833.09	83.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,612,178,500.00	910,590,700.00	701,587,800.00	56.5
210602	Тавилга	73,873,500.00	62,228,900.00	11,644,600.00	84.2
210604	Урсгал засвар	2,549,515,700.00	2,544,201,266.91	5,314,433.09	99.8
2107	Томилолт, зочны зардал	102,500,000.00	61,809,520.20	40,690,479.80	60.3
210701	Гадаад албан томилолт	87,500,000.00	50,858,084.00	36,641,916.00	58.1
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	10,951,436.20	4,048,563.80	73.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,196,838,500.00	571,139,867.00	625,698,633.00	47.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,066,290,300.00	464,277,504.00	602,012,796.00	43.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	15,500,000.00	15,000,000.00	500,000.00	96.8
210803	Даатгалын үйлчилгээ	2,123,500.00	1,946,600.00	176,900.00	91.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	678,600.00	497,419.00	181,181.00	73.3
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	9,500.00	133,500.00	6.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	77,550,000.00	55,526,171.00	22,023,829.00	71.6
210807	Газрын төлбөр	5,385,400.00	5,381,040.00	4,360.00	99.9
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	29,167,700.00	28,501,633.00	666,067.00	97.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	668,276,600.00	623,558,968.02	44,717,631.98	93.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	369,770,900.00	416,162,476.02	-46,391,576.02	112.6
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	298,505,700.00	207,396,492.00	91,109,208.00	69.5

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,025,503,000.00	598,661,088.71	426,841,911.29	58.4
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,025,503,000.00	598,661,088.71	426,841,911.29	58.4
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	996,753,000.00	591,151,088.71	405,601,911.29	59.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,750,000.00	7,510,000.00	21,240,000.00	26.1
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	86,061,180,700.00	73,108,343,087.51	12,952,837,612.49	85.0
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,350,305,000.00	63,306,435,031.51	6,043,869,968.49	91.3
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	69,350,305,000.00	63,306,435,031.51	6,043,869,968.49	91.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,710,875,700.00	9,801,908,056.00	6,908,967,644.00	58.7
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,767,923,300.00	5,363,663,721.50	404,259,578.50	93.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,863,009,500.00	4,438,224,334.50	1,424,765,165.50	75.7
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,079,942,900.00	-	5,079,942,900.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,092,874,182.93	-5,092,874,182.93	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	350,883,218.16	-350,883,218.16	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	824	824	-	100.0
620001	Удирдах ажилтан	10	10	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	595	595	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	219	219	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн үйл ажиллагааны зорилгыг "эмчилгээ, сувилгаа, үйлчилгээ, орчны шинэчлэлийг олон улсын түвшинд нийцүүлэн сайжруулж, инновац, эрдэм шинжилгээ судалгааны хамрах хүрээг өргөжүүлэн эмнэлгийн мэргэшсэн, нэгдмэл цогц, тусламж үйлчилгээг салбарын анхдагч, үндэсний манлайлагчаас дэлхийн жишигт хүргэхэд оршино" гэж тодорхойлжээ.

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь дараах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Тухайлбал:

- ЭМТҮ-г дэлхийн жишигт хүргэх чадварлаг хүний нөөцийг гүйцэтгэлийн үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоог бий болгох замаар хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж залгамж халааг тасралтгүй бэлтгэхэд оршино.
- ОУ-ын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх замаар оношилгоо, эмчилгээний шинэ технологи, инновац, сайн туршлага, менежментийг нэвтрүүлэн нутагшуулж, Монгол Улсад оношлогдож, эмчлэгдэх боломжгүй өвчний тоог бууруулахад чиглэгдэнэ.
- Байгууллагын санхүүгийн урт хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн менежмент, гүйцэтгэлийн удирдлагыг сайжруулах замаар санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг дэмжсэн уян хатан тогтолцоог хөгжүүлэхийг эрмэлзэж ажиллахад оршино.
- ОУ-ын сургалт эрхлэгч байгууллагуудын сургалтын загвар, дэвшилтэт арга барилыг төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн зэрэгцээ гадаад, дотоодын тэргүүлэх эрдэмтэн судлаачдын хамтарсан багийг бүрдүүлэн, эрдэм шинжилгээ, судалгааны хамрах хүрээг өргөжүүлж, судалгааны түвшнийг дээшлүүлж, эрдэм шинжилгээ, судалгааг дэмжсэн үнэлгээ, урамшуулал, хяналтын тогтолцоог бий болгоход оршино.
- Олон улсын магадлан итгэмжлэлийн стандартуудыг хангасан ээлтэй, эрсдэлгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчныг бүрдүүлж, чанарын удирдлагын тогтолцооны хамрах хүрээг өргөжүүлэн, өрсөлдөх чадвараа бэхжүүлэхэд оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Улсын нэгдүгээр төв эмнэлэг нь үйл ажиллагаандаа дараах хууль тогтоомжийг мөрдөж ажиллаж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийг үр нөлөөгүй байна гэж үнэлсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар судалж, танилцсан бөгөөд дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын 2018 оны А/26 дугаар тушаалаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тогтоомж, дотоод хяналтын стандарт, гүйцэтгэлийн санхүүжилтийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтай холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 20,936,049.7 мянган төгрөгөөр буюу 27.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,092,874.2	350,883.2	(4,741,990.0)
Авлага	3,372,550.7	16,903,438.0	13,530,887.3
Урьдчилгаа	209,555.8	36,827.5	(172,728.3)
Бараа материал	10,881,245.6	25,297,007.1	14,415,761.5
Үндсэн хөрөнгө	57,352,264.7	55,156,384.9	(2,195,879.8)
Нийт хөрөнгө	76,808,491.1	97,744,540.7	20,936,049.7
Өр төлбөр	1,631,476.9	20,538,412.3	18,906,935.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	75,177,014.1	77,206,128.4	2,029,114.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	76,808,491.1	97,744,540.7	20,936,049.7

Мөнгөн хөрөнгийн өмнөх оны үлдэгдлээс 4,741,990.0 мянган төгрөгийг тайлант оны эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр олгох санхүүжилтийг хугацааны хязгаарлалтаас шалтгаалан авч чадаагүйгээс дутуу зарцуулжээ.

Авлага дансны үлдэгдэлд Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийн 16,799,451.8 мянган төгрөгийн санхүүжилтийн авлага, ажилчидтай холбоотой авлага 8,412.1 мянган төгрөг, суралцагч эмчээс авах сургалтын төлбөрийн авлага 5,376.0 мянган төгрөг, түрээслэгч байгууллагуудаас авах түрээсийн болон ашиглалтын зардлын авлага 90,198.0 мянган төгрөг бүртгэлтэй байна.

Урьдчилгаа төлбөр өмнөх оны үлдэгдлээс 172,728.3 мянган төгрөгөөр буурч 36,827.5 мянган төгрөг болсон нь тус эмнэлгийн гал тогооны нэг давхрын их засварын ажлын гүйцэтгэлээр капиталжуулж бүртгэсэнтэй холбоотой ба оны эцсийн үлдэгдэлд эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилгын зураг төслийн 36,827.5 мянган төгрөгийн урьдчилгаа байна.

Бараа материалын үлдэгдэл 25,297,007.1 мянган төгрөгт хүрч 14,415,761.5 мянган төгрөгөөр өссөн ба үлдэгдэлд амбулаторийн эмийн сангийн дархлаа дарангуйлах эмийн үлдэгдэл 4,023,625.4 мянган төгрөг, "Астелас фарм" компаниас дархлаа дарангуйлагч эмийг урьдчилан авч нөөцөлсөн 3,606,802.6 мянган төгрөг, цусны хавдрын болон хими эмчилгээний тарианы 4,218,712.5 мянган төгрөг, нэн шаардлагатай өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгсэл 2,295,273.6 мянган төгрөгийн, яаралтай тусламжийн хэрэгцээнд 11,152,593.0 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийн 3 сарын нөөц байна. Үүнээс 677,029.5 мянган төгрөгийн үнэ бүхий эм, эмнэлгийн хэрэгсэл нь ашиглалтын хугацаа дууссан байна.

Үндсэн хөрөнгийн дансанд нийт 4,151,392.9 мянган төгрөг нэмэгдсэн. Үүнээс 966,671.2 мянган төгрөг нь ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, 2,217,444.6 мянган төгрөг нь барилга байгууламжийн капиталжуулалт, 967,274.2 мянган төгрөг нь худалдан авсан хөрөнгө байна. ТӨБЗГ-ын 2023 оны 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 755 дугаар тогтоолоор ашиглах боломжгүй болсон 852,733.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл ЭМДЕГ-аас тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр нэхэмжилсэн 16,799,451.8 мянган төгрөгийн санхүүжилт хугацааны хязгаарлалтаас шалтгаалж тайлант жилд шилжигдээгүйгээс ханган нийлүүлэгч байгууллагуудад өгөх өглөг өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 77,206,128.4 мянган төгрөг болж 2,029,114.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нэмэгдсэнтэй тус тус холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 87,938,708.2 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 11,291,838.8 мянган төгрөг, нийт орлого, зарлагыг 99,230,547.0 мянган төгрөг тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр тогтоолоор 2023 оны эмнэлгийн тусламж үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг ЭМД-ийн санхүүжилтээр 87,938,708.2 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 11,291,838.8 мянган төгрөг нийт зарлагыг 99,230,547.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж баталжээ.

ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 05-ний өдрийн 07 дугаар тогтоолоор төсвийн тодотгол хийж санхүүжилтийн эх үүсвэрийг 13,169,366.3 мянган төгрөгөөр бууруулж, нийт 86,061,180.7 мянган төгрөгөөр баталсан. Үүний 69,350,305.0 мянган төгрөг нь Эрүүл мэндийн даатгалын сангаас, 16,710,875.7 мянган төгрөг нь үйл ажиллагааны орлогоос санхүүжихээр тодотгожээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр нийт 73,108,343.1 мянган төгрөгийн мөнгөн орлого бүрдүүлсэн нь ТУЗ-өөр баталсан төлөвлөгөөт орлогоос 15.0 хувь буюу 12,952,837.6 мянган төгрөгөөр дутуу байна.

Нийт орлогын 63,306,435.0 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 9,801,908.1 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр урсгал үйл ажиллагааны зардалд нийт 77,850,334.0 мянган төгрөг зарцуулж төлөвлөсөн зардлаас 8,210,846.6 мянган төгрөг буюу 9.5 хувиар дутуу зарцуулсан нь эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэх санхүүжилт 15.0 хувиар дутуу олгогдсонтой холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

/мянган төгрөгөөр/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	86,061,180.7	77,850,334.1	8,210,846.6	90.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	75,726,640.9	73,855,946.4	1,870,694.5	97.5
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,025,503.0	598,661.1	426,841.9	58.4
1.3	83603	Нэмэлт- Дээд шатны төсвөөс хуваарилсан	4,229,093.9	3,395,726.6	833,367.3	80.3
1.4	1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	5,079,942.9	0.0	5,079,942.9	0.0

Эмнэлгийн тусламж үйлчилгээ хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх арга хэмжээ 97.5 хувийн биелэлттэй байгаа нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт дутуу төвлөрснөөс шалтгаалсан байна.

Ажил олгогчоос олгох тэтгэмж шагнал урамшууллын арга хэмжээ 58.4 хувийн биелэлттэй байгаа нь төлөвлөлтийг бодитой, судалгаа тооцоогүй төлөвлөсөнтэй холбоотой.

Дээд шатны төсвөөс хуваарилсан арга хэмжээ 80.3 хувийн биелэлттэй байгаа нь суралцагч эмч нарын тоо 107 болж буурч 3,234,907.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн нь нөлөөлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь тайлант онд нийт 64,975,317.3 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж, баталснаас 57,758,223.7 мянган төгрөгийн худалдан авалтыг хийжээ. Нийт зарласан тендерийн 49.0 хувь нь бараа, 51.0 хувь нь ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа байсан бөгөөд 73.0 хувийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 27.0 хувийг тендер шалгаруулалтын онцгой журмаар зохион байгуулсан байна.

Тухайлбал, нийт 49 тендер шалгаруулалт зохион байгуулсан ба эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах 55,679,104.8 мянган төгрөг, нормын хувцас, зөөлөн эдлэл 118,176.3 мянган төгрөг, хоолны материал 1,905,730.5 мянган төгрөг, бичиг хэргийн материал 127,492.4 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 633,345.5 мянган төгрөг, урсгал засварын ажил үйлчилгээ 835,000.0 мянган төгрөг, ХАА-ны төлөвлөгөөнд тусгагдаагүй давсан орлогоос хийсэн худалдан авалт МТ, компьютер, программ хангамжийн зардалд 362,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх зардалд 300,782.2 мянган төгрөг, хог хаягдлын зардалд 383,611.1 мянган төгрөг, хөтөлбөр болон төслийн дотоод урсгал зардалд 50,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах үндсэн хөрөнгө, орлого, анхан шатны баримт, дотоод хяналт, төлбөртэй тусламж үйлчилгээ, гэрээний хэрэгжилт болон шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Тэд-Аудит” ХХК-ийн ахлах аудитор Н.Дэлгэрмаа, аудитор Г.Эрдэнэчимэг нар гүйцэтгэж, анхан шатны чанарын хяналтыг аудит менежер В.Оюунчимэг, ерөнхий захирал Ц.Сугармаа нар, дараагийн шатны чанарын хяналтыг ахлах аудитор В.Эрдэнэцогт, аудитын менежер Ц.Хосжаргал, Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/162 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн 96,631,990.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 1,449,479.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан төсвийн байгууллагад хамаарах 29 шалгуур үзүүлэлтийн дагуу нарийвчилсан горим, сорил хэрэгжүүлснээр цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээний тайлант жилийн балагдсан төсвөөс 167,735.5 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 3,381.5 мянган төгрөг, норматив зардлыг 3,923,359.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэжээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дээрх хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгасан.

Тайлант онд нийт 159 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 148 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй байна. Мэдээлээгүй мэдээлэл нь хандив, тусламжийн зарцуулалтын тайлан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн тайлант онд нийт 57,758,223.7 мянган төгрөгийн худалдан авалт хийж гүйцэтгэлийг “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын Хавсралт 22-т тодорхойлсон агуулгын дагуу Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны “Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт” цэс дэх “Худалдан авалтын тайлан/гүйцэтгэл” мэдээлэлд худалдан авалтын гэрээ тус бүрийн үнийн дүн, гүйцэтгэгчийн нэр, гэрээний дугаарыг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4.1. “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд

дараах зарчмыг баримтална: 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.2.мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх; 4.1.4.хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" болон ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар албан шаардлага хүргүүлэх.

4.4.2 Бусад хууль тогтоомж

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендерээр ханган нийлүүлэх байгууллагуудтай хийж байгаа зарим гэрээний хамрах хугацааг 2023 оны 3 дугаар сараас 2024 оны 4 дүгээр сар хүртэлх хугацаагаар он дамжуулан хийсэн нь Төсвийн тухай хуулийн 7.1, 7.3, 43.5-д заасан: "төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно", "төсвийг 1 жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан хэрэгжилтийг зохион байгуулах", "төсвийн захирагч нь төсвийг 2 төсвийн жил дамжуулан зарцуулахгүй гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ханган нийлүүлэгч байгууллагуудтай хийж байгаа бараа, ажил үйлчилгээ болон эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад үйлчилгээ худалдан авах гэрээний хугацааг тайлант жилд багтаах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах зөвлөмж өгөх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнд нийт 1,798,359.2 мянган төгрөгийн 13 асуудлыг илрүүлж, асуудлын бүртгэлээр зөвлөмж өгч, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хяналт хийж залруулагдаагүй 801,803.8 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчлийг аудитын тайланд тусгасан болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгөгдсөн ба хэрэгжилт дараах байдалтай байна. Тухайлбал:

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	6	171,796.0	6	171,796.0	100.0
Албан шаардлага	1	41,887.1	1	41,887.1	100.0
Нийт дүн	7	213,683.1	7	213,683.1	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус эмнэлэг дээр төрөлжсөн мэргэшлээр суралцаж буй резидент эмч нарын сургалтын төлбөрийн болон цалин, үр дүнгийн урамшууллыг бодитой олгож байгаа эсэхэд аудит хийхэд чиглэнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 120,229.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 120,229.4 мянган төгрөгийн алдааг залруулсан.

Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх оны аудит хийгдсэн тайлангийн эцсийн үлдэгдэлтэй тулган шалгахад бусад авлагын дүн 120,229.4 мянган төгрөгөөр илүү зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС1 стандартын 79-р

заалттай нийцээгүй, "нийцсэн ба зохистой байх батламж мэдэгдэл"-ийг хангаагүй байсныг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 681,574.3 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс 663,459.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 18,115.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт 681,574.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 1,449,479.8 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Нийслэлийн авто зам хөгжлийн газрын 2022 оны 04 сарын 22-ны өдрийн 6/702, ТӨБЗГ-ын 2022 оны А/1/1890 дугаар албан тоотыг тус тус үндэслэн нийслэлийн замын төсвийн хөрөнгөөр баригдсан 655,110.8 мянган төгрөгийн өртөгтэй 16 суудлын автомашины багтаамжтай "Кар сити" давхар зогсоолыг хүлээн авч хөрөнгөөр бүртгэсэн боловч одоог хүртэл ашиглалтгүй байгаа нь ТӨБЗГ-ын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2."Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авч, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

2. "Тэлмэн халиун" ХХК-тай ажлын байрны таатай орчин бүрдүүлэх зорилгоор халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварт өвчин үүсгэгч нян тээгч, дамжуулагч, ахуйн хортон шавьж мэрэгчийг устгах болон тандалт судалгаа хийх зэрэг ажлуудыг гүйцэтгүүлэхээр 121/12 болон 139/23 дугаар бүхий "Хортон шавьж устгалтын гэрээ"-г хийсэн байна. Гэрээнд гэрээний эхлэх, дуусах хугацааг заагаагүй, ажлын гүйцэтгэл нь тодорхойгүй, тандалт судалгаа, тооцооны дүн шинжилгээ хийсэн баримтгүй, халдваргүйтэл, шавьжгүйтэл, мэрэгч устгалын ажлын тайлан байхгүй, хэдий хэмжээний талбайг хамруулсан, халдваргүйжилт хийсэн эсэхийг холбогдох хүмүүсээр баталгаажуулаагүй, гэрээ байгуулсан даруйд ажлын гүйцэтгэл 100 хувийн биелэлтэй гэж акт үйлдэн, ажлын хөлсийг бүрэн олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээт ажлын гүйцэтгэл, гаргасан дүгнэлтэд үндэслэн санхүүжилтийг олгож байх, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төлбөртэй тусламж үйлчилгээний орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант жилд төлбөртэй тусламж үйлчилгээний орлогын төлөвлөгөөг 12 тасагт сар бүр 58 ор ажиллуулж, 591.0 мянган төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний биелэлтийг баталгаажуулахад орны эргэлтийн тоог хуанлийн календарийн хоногоор тооцоогүй, дунджаар 25 хоногоор тооцсон нь орлогыг үндэслэлтэй, бодитой төлөвлөхгүй байна. Жишээ нь: VIP өрөөнүүдийн 5 дугаар сарын 01-ээс 11 дүгээр сарын 06-ыг хүртэлх хугацаанд төлбөртэй өрөөнд хэвтсэн өвчтөнүүдийн бүртгэлийг тулган үзэхэд сар бүрийн 25-30-ны өдрийн хооронд хэвтсэн хүний тоо 130 бөгөөд үүнээс 19 хүний төлбөрийг авсан эсэх нь тодорхойгүй, төлбөртэй ор ажиллуулах батлагдсан журам байхгүй, тасгийн эрхлэгч болон ахлах сувилагч нар сар бүр төлбөртэй орны орлогын тайлан гаргадаггүй, нягтлан бодогч түүнд хяналт тавьж ажилладаггүй, зөвхөн төлөгдсөн төлбөрийн дүнгээр орлогыг бүртгэсэн, зарим

өвчтөний хэвтэн эмчлүүлсэн орны төлбөрийг чөлөөлдөг зэрэг асуудлууд байгаа нь Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 49, /118 дугаар тушаалаар баталсан "төрийн өмчийн Эрүүл мэндийн байгууллагуудаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж үйлчилгээний жишиг хэмжээ", "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх нэмэлт тусламж үйлчилгээнээс оруулсан орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-ын 2.1."...олсон орлогыг бодитой төлөвлөж, жил бүр төсөвт тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй боловсруулж, ТУЗ-өөр батлуулах, төлбөртэй орны орлогыг төвлөрүүлэх тухай журам боловсруулж, орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах.

2. Төлбөртэй үйлчилгээний жишиг хэмжээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 49/A118 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ, журам"-д төлбөртэй үйлчилгээний өрөөг энгийн бол 10.0-30.0 мянган төгрөгөөр, хагас люкс бол 30.0-60.0 мянган төгрөгөөр тогтоосон боловч тус эмнэлгийн захирлын 2022 оны A/170 тушаалаар төлбөртэй үйлчилгээний өрөөний үнийг жишиг хэмжээний дээд хязгаараар буюу 40.0-60.0 мянган төгрөгөөр тогтоосон байна. Мөн АТГ-аас 2023 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 02/19217 дугаар албан бичгээр A/170 тушаалыг хүчингүй болгох тухай зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмж:

"Төлбөрийн жишиг хэмжээ, журам"-д заасан нэмэлт төлбөрийн жишиг хэмжээг баримталж, төлбөртэй үйлчилгээний өрөөний орлогыг бүрдүүлэх.

3. Дотоод аудиттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус байгууллагын удирдлага нь дотоод аудитын үйлчилгээ үзүүлэхээр иргэн Д.Чулуунбаттай нэг сарын 2,500.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгохоор нийт 6 сарын хугацаатай (2022 оны 11 дүгээр сарын 17-ноос 2023 оны 5 дугаар сарын 17) гэрээ байгуулжээ. 2023 оны эхний хагас жилд баталсан төлөвлөгөөгөөр 15 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд үүнээс 7 ажлыг хийж тайлагнасан, 8 ажлыг гүйцэтгэсэн талаар ажлын тайлан байхгүй, ажлын гүйцэтгэл нь баримтаар нотлогдохгүй байна. Ийнхүү гэрээ болон төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг бүрэн хийж гүйцэтгээгүй байхад ажлын хөлсийг бүрэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3, 6.4.1-д заасан "Санхүү, төсвийг зохистой удирдах, төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дотоод аудиторын сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод, үр дүнтэй зохион байгуулж дотоод аудитыг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдлийг өмнөх аудит хийгдсэн тайлангийн эцсийн үлдэгдлээс зөрүүтэй	1	120,229.4			1	120,229.4	1	120,229.4				
Дүн					1	120,229.4	1	120,229.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтгүй хөрөнгө байна.	1	655,110.8			1	655,110.8						
Анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагын хүлээн зөвшөөрсөн	1	8,348.5			1	8,348.5						
Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг бодитой төлөвлөөгүй	1	7,980.0					1	7,980.0				
Дотоод аудитын зөвлөх үйлчилгээний гэрээний биелэлт хангалтгүй	1	10,135.0					1	10,135.0				
Төлбөртэй үйлчилгээний ерөөний үнийг	1						1	-				

**Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

жишиг хэмжээний дээд хязгаараар буюу 40.0-60.0 мянган төгрөгөөр тогтоосон байна												
Дүн	5	681,574.3			2	663,459.3	3	18,115.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
1 мэдээлэл байршуулаагүй, 6 мэдээлэл хугацаа хоцроосон	1	-	1	-		
Дүн	1	-	1	-		
<i>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>						
Төсвийн тухай хуулийн 7.1, 7.3, 43.5 заалттай нийцээгүй	1	-			1	-
Дүн	1	-			1	-
Нийт дүн	2	-			2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

оны

02

дугаар сарын

23

№

50 / А0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/20 /НА-ЕТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод мэдээллийг байршуулахаас 1,564,520,400.00 (нэг тэрбум таван зуун жаран дөрвөн сая таван зуун хорин мянга дөрвөн зуу) төгрөгийн 1 мэдээллийн гүйлгээг мэдээлээгүй, худалдан авалтын 57,758,223,700.00 (тавин долоон тэрбум долоон зуун тавин найман сая хоёр зуун хорин гурван мянга долоон зуу) төгрөгийн гэрээний гүйцэтгэлийн дүн тайлагнаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" -д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Хишигжаргал/, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТЭД-АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ц.СУГАРМАА

0001080130



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024

он

02

дугаар сарын

23

№ 51/А0150055

Улаанбаатар хот

СНАГ-2024/20 ИНА-СТА-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

"Тэлмэн халиун" ХХК-тай байгуулсан 121/12 болон 139/23 дугаар бүхий "Хортон шавьж устгалтын гэрээ"-нд гэрээний эхлэх, дуусах хугацааг заагаагүй, ажлын гүйцэтгэл нь тодорхойгүй, тандалт судалгаа, тооцооны дүн шинжилгээ хийсэн баримтгүй, халдваргүйтэл, шавьжгүйтэл, мэрэгч устгалын ажлын тайлан байхгүй, хэдий хэмжээний талбайг хамруулсан, халдваргүйжилт хийсэн эсэхийг холбогдох хүмүүсээр баталгаажуулаагүй, гэрээ байгуулсан даруйд ажлын гүйцэтгэл 100 хувийн биелэлтэй гэж акт үйлдэн, ажлын хөлсийг бүрэн олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д заасан "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Гэрээний гүйцэтгэлд үндэслээгүй санхүүжилтийг олгосон зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Хишигжаргал/, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТЭД-АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ

Ц.СУГАРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тэнгүү-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26-30

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-14.Docs

0001080158



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 дугаар сарын 23 № 52/А0150055
СНАГ- 2024/20 /НА-СТА-ТМЗ
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийслэлийн авто зам хөгжлийн газрын 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 6/702, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны А/1/1890 дугаар албан тоот шийдвэрүүдийг үндэслэн нийслэлийн замын төсвийн хөрөнгөөр баригдсан 655,110,827.00 (зургаан зуун тавин таван сая нэг зуун арван мянга найман зуун хорин долоо) төгрөгийн өртөгтэй 16 автомашины багтаамжтай "Кар сити" давхар зогсоолыг тус эмнэлэгт хүлээлгэн өгсөн боловч одоогоор ашиглаж, үйл ажиллагаа явуулаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Төрийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.2.2-т: "Зөвлөл нь төрийн өмчийг үрэгдүүлэх, үнэгүйдүүлэх, чанар байдлыг доройтуулах, эвдэж гэмтэх зэрэг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эзэмшилт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, бүртгэл, ашиглалтад хяналт тавих, үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллах үндсэн үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Автомашины зогсоолыг ашиглахгүй байгаа зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Ерөнхий захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Хишигжаргал/, ахлах нягтлан бодогч /Н.Урансүрэн/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТЭД-АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

(Signature)

Ц.НАРАНЧИМЭГ
Ц.ХОСЖАРГАЛ
Ц.СУГАРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тосруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-26 30

Z:\Alban Sheardlaga\2024\0223 SNAG-14 Docx

000 080 156

ТЭМДЭГЛЭЛ

This image shows a full page of white paper with horizontal dashed lines, typical of primary school writing paper. The lines are evenly spaced and run across the width of the page. There are no margins, text, or other markings on the paper.

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр

Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг

Улаанбаатар-15160, Монгол Улс